

ШАРГА СУМД 2018 ОНЫ 2 ДУГААР САРД БОЛСОН  
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2018.02.26

Баянгол

ХАМТЫН ХҮЧ БАГИЙН МАЛЧИН Б.ДАШМЯГМАР УЛСЫН АВАРГА  
МАЛЧИН БОЛЛОО

Сар шинийн босгон дээр тус сумын Хамтын хүч багийн малчин Б.Дашмягмар улсын аварга тэмээчнээр шалгарсан байна. Аварга малчны шагналыг УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд болон аймаг, сумын удирдлагууд гардууллаа.

АЙМАГ, СУМЫН АВАРГА МАЛЧИД ТОДОРЛОО

Энэ онд **аймгийн аварга малчнаар** Баянгол багийн малчин Т.Тайван, Ц.Ганболд, Хамтын хүч багийн малчин Н.Мөнхжаргал, Сондуулт багийн малчин Б.Гомбосүрэн, Улаантуг багийн малчин Н.Гомбодорж нар тодорлоо. **Сумын аварга малчнаар:** Баянгол багийн малчин Д.Дамдиндорж, Х.Гантөмөр, О.Гантөмөр, Б.Батхишиг, Д.Батбаатар, Хамтын хүч багаас Ж.Отгонбаяр, Ж.Нямжаргал, Д.Ууганбаатар, Р.Отгонбаатар, Сондуулт багаас Б.Ариунболд, Г.Гансүх, Г.Нямбаяр, Д.Дунданхүү, Улаантуг Л.Дамдинсүрэн, В.Төмөр-Очир, Б.Оросбат, Х.Гантөмөр, Д.Саруултайван, Ж.Долгоржав

**Сумын алдарт уяачаар:** Баянгол багийн Б.Батбаатар, Ц.Дүүрэнбаяр, Т.Буджав, Хамтын хүч багаас М.Батаа, Д.Ганзориг, Ж.Отгонбаяр, Сондуулт багаас Л. Батхүү, Улаантуг багаас А.Батцоож,

**Сумын мянгат малчнаар** Хамтын хүч багаас Х.Лхагвадорж, Б.Баатар, Н.Мөнхжаргал, Г.Ган-Очир, Баянгол багаас Д.Дамдиндорж, Х.Гантөмөр, Сондуулт багаас М.Батцэнгэл, Ш.Баянжаргал, Х.Төмөрбаатар, Л. Рэнцэндорж, Улаантуг багаас М.Доржсүрэн, Б.Очирсүрэн, П.Баярбилэг, Д.Дунданхүү, Сумын тэргүүний хадланчаар Ш.Баярлах, Сумын тэргүүний тариаланчаар Б.Нэргүй нар тодорлоо. Сумын аваргуудын болон засгийн газрын шагналаар шагнагдаж байгаа хүмүүсийн шагналыг битүүлэгний үеэр гардууллаа.



## МЭДЭЭЛЛИЙН ЦАГИЙГ ХИЙЛЭЭ

Засгийн газрын тогтоолын дагуу 14 хоногт 1 удаа зохион байгуулдаг мэдээллийн цагийг энэ сарын 5, 19-ний өдрүүдэд зохион байгууллаа. Мэдээллийн цагаар сумын удирдлагууд цаг үеийн ажил танилцуулж үүрэг даалгаврыг өгч ажилласан. Мөн халамжийн мэргэжилтэн Г.Өлзийсайхан, Нийгмийн даатгалын байцаагч Б.Хорлоожав нар шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоомж, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл хийлээ. Мэдээллийн албан байгууллагуудын дарга эрхлэгч нар, ЗДТГ-ын мэргэжилтнүүд, цагдаа, хэсгийн төлөөлөгч, эрчим хүчний салбарын эрхлэгч нар хамрагддаг.

МАЛЧДАД ТУСЛАХ ХАНДИВЫН АЯН ҮРГЭЛЖИЛСЭЭР...

Жавзандамба хутагт төвөөс цаг агаар хүндэрч байгаа энэ үед Н.Баттөмөр, Д.Ганзориг, М.Эрдэнэсүвд, Д.Төртулга, Л.Эрдэнэжаргал, О.Оюунтунгалаг, Л.Нэргүйбаатар, Баг.Батсайхан, Н.Бөхтөмөр, Н.Дарьбазар, Д.Баттөр, О.Оюун, С.Багмид, Д.Мөнхбат, Б.Нэргүйжанцан, Б.Доржгарав, Д.Батдэлгэр, Су.Даваадорж, Ш.Халзантуухай, нарын 19 өрхөд тусламж өглөө.



Төрийн банкнаас малчдад өвс, нэмнээ, ажлын бээлий зэргийг хандивлалаа.

Мөн төрийн байгууллагууд хандивын аян өрнүүлж малчдад туслах ажлыг зохион байгуулсан.



### ТӨРИЙН АЛБАН ХААГЧДААС МОНГОЛ ХЭЛНИЙ ШАЛГАЛТ АВЛАА

Сумын төрийн байгууллагуудын албан хэрэг хөтөлдөг ажилтан бүр зөв бичих, найруулга зүй, албан хэрэг хөтлөлтийн сургалтанд хамрагдан, 2 сарын 9-ний өдөр шалгалт өгсөн.



2018.01.18 –ны өдөр сургуулийн дотоод хяналтын нэгж “Хүүхэд хүлээж авах бэлтгэл ажлыг шалгах” удирдамж боловсруулан хичээлийн танхим, дотуур байр гэсэн 2 чиглэлээр шалгаж, хяналт шалгалтын мөрөөр гарсан давуу тал, сул тал, эрсдэлт хүчин зүйлийг сургуулийн удирдлагад танилцуулан холбогдох хүмүүст хүргүүлсэн.



Хальтиргаа гулгаа их байгаа учраас эцэг эхийн зөвлөлийн санаачлагаар сургуулийн сургуулийн эргэн тойрны гарц, тойрог, булангийн цасыг цэвэрлэлээ.



бэлтгэн оролцуулж, амжилттай оролцлоо.



Аймгийн аварга шалгаруулах хүүхдийн спортын наадам 2018 оны 2 сарын 9-11-ний хооронд Алтай хотод зохион байгуулагдаж, биеийн тамирын багш Ч.Тогтохням 50 сурагчийг 6 төрлөөр



Волейболын төрөлд: Эрэгтэй 1-р байр

- 12 ангийн сурагч Г.Цэвэгмэд
- 12 ангийн сурагч Т.Ойдовгарав
- 12-р ангийн сурагч Л.Гүндсамбуу
- 12-р ангийн сурагч П.Буд-Эрдэнэ
- 12-р ангийн сурагч Ч.Алтангэрэл
- 11-р ангийн сурагч Г.Мягмардорж
- 11-р ангийн сурагч Г.Нямбаатар
- 10а ангийн сурагч Д.Дүүрэнжаргал

Жү-до бахийн бага насны төрөлд

- 50 кг -4а ангийн сурагч Г.Тэмүүлэн 1-р байр, алтан медаль

- +50 кг 5а ангийн сурагч Б.Мөнхцоож 2-р байр, мөнгөн медаль

Дунд, ахлах нас:

- 46 кг -8а ангийн сурагч Б.Эрхбаяр 1-р байр, Алтан медаль
- +57 кг- 8а ангийн сурагч Г.Отгонбаяр 1-р байр, Алтан медаль
- 50 кг -9а ангийн сурагч М.Эрдэмтөгс 2-р байр, мөнгөн медаль
- 73 кг -10 а ангийн сурагч Б.Дашдаваа 2-р байр, мөнгөн медаль
- 52 кг -9а ангийн сурагч А.Ундрах 3-р байр, Хүрэл медаль
- 52 кг -7 ангийн сурагч Г.Анударь 3-р байр, Хүрэл медаль

Чөлөөт бөхийн төрөлд:

- 76 кг -10а ангийн сурагч Б.Дашдаваа 1-р байр, Алтан медаль
- 48 кг -8а ангийн сурагч Б.Эрхбаяр 2-р байр, Мөнгөн медаль
- 60 кг -10 ангийн сурагч Б.Жамьянпүрэв 3-р байр, хүрэл медаль
- 69 кг -10а ангийн сурагч Т.Хосбаяр 3-р байр, Хүрэл медаль
- +70 кг -9а ангийн сурагч Б.Пүрэвсүэрн 3-р байр, Хүрэл медаль

2 сарын 8-нд сумын хэсгийн төлөөлөгч н.Ууганбаатар, эрүүл ахуйн байцаагч Б.Гантулга нар үдийн цайны эрүүл ахуй, чанар, стандартад хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтын мөрөөр гарсан зөрчил дутагдлыг арилгах, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, үдийн цайнд тавигдах журмыг мөрдөж ажиллахыг зөвлөлөө.



Сумын засаг даргын захирамжаар “Оюунлаг Алтай”, “Сургалтын чанарыг ахиулах”, “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдаж, 2018 онд хийх ажлын төлөвлөгөө гарган, БСУГ-т хүргүүлээ.

2018 оны ЭЕШ-ын журмыг 12-р ангийн сурагчид болон эцэг эхчүүдэд танилцууллаа.

2018 оны 2 сарын 6-нд Алтай хотод Орос хэлний олимпиадад багш Б.Оюунгэрэл, 9а ангийн сурагч Э.Энхболор, 12а ангийн сурагч Б.Болорчулуун нар оролцлоо. Сурагчдын англи хэлний боловсрол бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилттой “Creative writing” уралдаанд 9 ангийн сурагч С.Даваахишиг, 10а ангийн сурагч Г.Номин, 11а ангийн сурагч Т.Дэлгэрзаяа, 12а ангийн сурагч М.Хонгорзул нар оролцлоо.

Мэдээ бэлтгэсэн: ДАШБХ мэргэжилтэн Д.Ончимэг